



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

1 Нифай 3:7

Би явж бас биелүүлэх болно.

Агуулга

Их Эзэн Нифай болон түүний ах нарт гуулин ялтсуудыг авахаар Иерусалим руу буц хэмээн зарлигдав.

Сургаал буюу зарчим

Их Эзэн бидэнд зарлиг өгөхдөө гүйцэтгэх арга замыг нь бэлдсэн байдаг.

Биелэлт

Их Эзэн чамд ямар хэцүү зүйлийг хийхийг зарлигдаж байсан бэ? Тэрээр зарлигийг гүйцэлдүүлэх замыг чамд хэрхэн бэлдэж өгсөн бэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 2:25

Адам хүмүүн байж болохын тулд унасан.

Агуулга

Лихай Уналт нь зайлшгүй тохиох ёстойг, мөн үүний үр дагаврын талаар хөвгүүддээ заажээ.

Сургаал буюу зарчим

Уналт нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд бидний мөнх бус оршихуйг боломжтой болгосон юм.

Биелэлт

Уналт болон мөнх бус байдлын талаарх мэдлэг нь энэ амьдрал дахь өөрийн зорилгыг илүү сайн ойлгоход тань хэрхэн тусалдаг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 2:27

Бид сонгох эрх чөлөөтэй.

Агуулга

Лихай хөвгүүддээ авралын төлөвлөгөөнд сонгох эрх ямар үүрэгтэйг заажээ.

Сургаал буюу зарчим

Бид эрх чөлөө болон мөнх амьдрал руу хөтлөх Христийг эсвэл боолчлол болон үхэл рүү хөтлөх чөтгөрийг дагах эсэхээ сонгох эрхтэй.

Биелэлт

Зарлигуудыг дагахаар сонголт хийсэн үеэ сана. Дуулгавартай байдал таныг гайхалтай эрх чөлөө рүү хөтөлсөн буюу хөтлөх үед танд ямар мэдрэмж төрдөг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 9:28–29

Хэрэв бид Бурханы зөвлөмжийг дагах аваас суралцах нь сайн хэрэг.

Агуулга

Иаков Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний агуу байдал болон чөтгөрийн зальт төлөвлөгөөг харьцуулжээ.

Сургаал буюу зарчим

Тэд өөрсдийн мэргэн ухаанд бардамнан сагсуурч, Бурханы зөвлөмжийг үл ойшоодог. Бурханыг дуулгавартай дагахын тулд мэдлэг хуримтлуулах нь сайн хэрэг.

Биелэлт

Бурханы зөвлөмжүүдэд дуулгавартай байх нь дэлхийн мэргэн ухааны мөн чанарыг танихад хэрхэн тусалдаг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 25:23, 26

Ач ивээлээр л бид аврагдана.

Агуулга

Нифай хүн төрөлхтөн яагаад зөвхөн Есүс Христээр дамжин аврагддаг шалтгааныг тайлбарлажээ.

Сургаал буюу зарчим

Бид чадах бүхнээ хийсний дараа Есүс Христээр дамжин нүглийн ангижралыг хүлээн авч, ач ивээлээр аврагдана.

Биелэлт

Хожмын Үеийн Гэгээнтнүүд Есүс Христэд итгэдэг үү? гэж хэн нэгэн асуувал та ямар мэдрэмж болон гэрчлэлээ хуваалцах вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 28:7–9

Бид ямар ч гэм нүглийг зөвтгөх ёсгүй.

Агуулга

Бошиглогч Нифай өөрийн хүмүүст хожмын өдрүүдэд тохиолдох ёс бус явдлуудын талаар заав.

Сургаал буюу зарчим

Эцсийн өдрүүдэд олон нь хуурамч, хоосон, мунхаг сургаалуудыг заах болно.

Биелэлт

Та дэлхийн мунхаг сургаалуудыг хэрхэн таньж мэдэх вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 31:19–20

Эцсийг хүртэл тэвч.

Агуулга

Нифай номлолынхоо төгсгөлд мөнх амьдралыг өвлөн авахын тулд бүх хүн Есүс Христийн үлгэр жишээг дагах ёстойг бичиглэв.

Сургаал буюу зарчим

Бид итгэлээ хөгжүүлж, нүглээ наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсны дараа мөнх амьдралыг өвлөн авахын тулд зөв шударга байдалд урагш тэмүүлэн, эцсээ хүртэл тэвчих ёстой.

Биелэлт

Та саяхан баптисм хүртсэн Сүмийн гишүүнд ямар зөвлөгөө өгөх вэ? “Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэхийн” тулд та юу хийж байна вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 32:3

Христийн үгэн дээр найрла.

Агуулга

Есүс Христийн сургаалыг ойлгож, үүний дагуу амьдрахын тулд хүмүүс юу хийх ёстойг Нифай номлолынхоо төгсгөлд бичиглэжээ.

Сургаал буюу зарчим

Хэрэв бид Христ болон Түүний үйлчлэгчдийн үгсээс суралцвал зөв сонголтуудыг хийх удирдамжийг хүлээн авах болно.

Биелэлт

Хийх ёстой зүйлээ мэдэж авахад тань Христийн үгс хэрхэн нөлөөлсөн бэ? Та Христийн үгэн дээр “найрлахын” тулд юу хийх вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

2 Нифай 32:8–9

Та нар үргэлж залбирах ёстой.

Агуулга

Есүс Христийн сургаалыг ойлгож, үүний дагуу амьдрахын тулд хүмүүс юу хийх ёстойг Нифай номлолынхоо төгсгөлд бичжээ.

Сургаал буюу зарчим

Сүнс бидэнд залбирахыг сургадаг.

Биелэлт

Та өглөө, орой залбирах ёстойгоо хэрхэн санадаг вэ? Та өөрийн залбиралдаа Ариун Сүнсний нөлөөг хэрхэн эрэлхийлдэг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Мозая 2:17

Бусладаа үйлчилж байгаа нь Бурхандаа үйлчилж буй хэрэг.

Агуулга

Хаан Бенжамин хүмүүстээ хандан үг хэлж, тэднийг Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авахад нь бэлджээ.

Сургаал буюу зарчим

Бид бусдад үйлчлэх үедээ Бурханд үйлчилдэг.

Биелэлт

Та нар эргэн тойрондоо байгаа хүмүүст Аврагчийн хийх байсан ямар зүйлсийг хийж өгч чадах вэ?

23 Учир нь бид Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ мөн түүнчлэн ах дүүстээ ятгахын тулд бичихээр хичээнгүйлэн хөдөлмөрлөв; учир нь бид ач ивээлээр л бид аврагдана гэдгийг мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу.

26 Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглолуудынхаа дагуу бичдэг болой.

17 Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.

28 Ай тэр хилэнцэт нэгний зальт төлөвлөгөө! Ай хүмүүний бардам зан, мөн эмзэглэл, мөн мунхаглал! Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс анхаардаг, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэдний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгнө. Мөн тэд мөхөх болно.

29 Гэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг.

8 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нар зүрх сэтгэлдээ тунгаасаар буйг би ухамсарлаж байна; мөн би энэ зүйлийн талаар ярих ёстой болсон нь намайг гонсойлгож байна. Учир нь хэрэв та нар хүмүүнд залбирахыг сургах Сүнсийг анхааран аваас, та нар залбирах ёстойг мэдэх бөлгөө; өөрөөр хэлбэл хилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана, харин тэрээр залбирах ёсгүйг түүнд сургадаг.

9 Гэвч болгоогтун, та нар үргэлж залбирах ёстойг мөн шантрах ёсгүйг би та нарт хэлье; та нарын үйл бодгальд тань золтой байж болохын тулд тэр та нарын үйлийг та нарт ариулахын тулд юун түүрүүнд та нар Христийн нэрээр Эцэгт залбирахаас өөр нэгээхэн ч зүйлийг Их Эзэнд үйлдэх ёсгүй.

27 Иймийн тул, хүмүүн нь бие махбодийн дагуу чөлөөт болой; мөн хүнд шаардлагатай болох бүх зүйл тэдэнд өгөгдсөн билээ. Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй; учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг бөлгөө.

3 Тэнгэр элчүүд Ариун Сүнсний хүчээр ярьдаг; иймийн тул, тэд Христийн үгсийг ярьдаг. Иймийн тул, би та нарт хэлсэнчлэн, Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно.

25 Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.

19 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.

20 Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно.

7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцэгтээ хандаж хэлрүүн: Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг бие-лүүлэх болно.

7 Тийм ээ, мөн ийнхүү хэлэх нь олон байх болно: Ид, уу, мөн баяс, учир нь маргааш бид үхнэ; мөн энэ нь бидэнд сайн байх болно.

8 Мөн үүнчлэн ийнхүү хэлэх нь олон байна: Ид, уу, мөн баяс; гэсэн хэдий ч, Бурханаас эмээ — тэр бяцхан нүгэл үйлдсэнийг зөвтгөнө; тийм ээ, бяцхан худал хэл, өөр нэгийг түүний үгсийнх нь учир далимдуул, хөршүүддээ нүх малт; үүнд хор хөнөөл гэж үгүй; мөн эдгээр бүх зүйлийг хий, учир нь маргааш бид үхнэ; мөн хэрэв түүнчлэн байснаар бид буруутай аваас, Бурхан биднийг хэдхэн удаа ташуурдах болно, мөн эцэст нь бид Бурханы хаант улсад аврагдах болно.

9 Тийм ээ, мөн тэд ийм маягаар, хуурамч мөн хоосон мөн мунхаг сургаалуудыг заах бөлгөө, мөн зүрх сэтгэлдээ ихэмсэглэдэг, мөн бодол санаагаа Их Эзэнээс нуухаар гүнзгий эрэлхийлэх тэд олон байх болно; мөн тэдний ажлууд харанхуйд байх болно.



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Мозая 3:19

Эгэл хүн Бурханы дайсан.

Агуулга

Хаан Бенжамин хүмүүстээ хандан үг хэлж, тэднийг Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авахад нь бэлджээ.

Сургаал буюу зарчим

Бид Есүс Христийн цагаатгалаар дамжин Ариун Сүнснийг хүлээн авч, гэгээнтэн болсноор эгэл хүнээ орхидог.

Биелэлт

“Ариун Сүнсний нөлөөнд автах” гэж юу вэ? Ариун Сүнс танд нөлөөлсөн жишээ бий юу?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Мозая 4:30

Өөрсдийн бодлууд, үгс, мөн үйлүүдээ хяна.

Агуулга

Хаан Бенжамин хүмүүстээ хандан үг хэлж, тэднийг Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн авахад нь бэлджээ.

Сургаал буюу зарчим

Бид өөрсдийн үг, үйлдэл, бодлоороо шүүгдэж, энэ бүхний төлөө хариуцлага хүлээнэ.

Биелэлт

Та өдрийн туршид цэвэр ариун бодол санаа, үг, үйлдлийг харуулахын тулд тодорхой ямар үйлдлүүд хийж байсан бэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Алма 7:11–13

Есүс Христ нүгэл болон үхлийг ялсан.

Агуулга

Алма Гидеоны хүмүүст Аврагч дэлхийд ирнэ, тэд өөрсдийгөө бэлтгэх ёстой хэмээн бошиглов.

Сургаал буюу зарчим

Есүс Христ өөрийн хүмүүсийн өвчин шаналал, алдсуудыг өөр дээрээ авсан; Тэр хүмүүнийг үхлээс чөлөөлж, нүглийг ялах замыг бэлдсэн.

Биелэлт

Та Цагаатгалын эдгээх хүчийг хэзээ мэдэрсэн бэ? Цагаатгалын эдгээх хүчний талаар найзтайгаа гэрчлэлээ хуваалцах буюу тэмдэглэлдээ бич.



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Алма 32:21

Итгэл нь төгс мэдлэг биш юм.

Агуулга

Алма дарууссан Зорамчуудад итгэл болоод бишрэлийн талаар заав.

Сургаал буюу зарчим

Итгэл нь хүмүүнийг үнэн боловч үл харагдах зүйлд найдахыг шаарддаг.

Биелэлт

Та үл харагдавч үнэн болох тэр зүйлийг найздаа хэрхэн тайлбарлах вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Алма 37:35

Насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун.

Агуулга

Алма Хиламанд өөрийгөө удирдагч болгон төлөвшүүлэхийг зөвлөв.

Сургаал буюу зарчим

Насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сур.

Биелэлт

Зарлигуудад дуулгавартай байх хүслийг бадраасан ямар туршлага танд байдаг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Алма 39:9

Нүдээрээ шунасны араас дахин бүү яв.

Агуулга

Алма ноцтой гэм нүгэл үйлдсэн Кориантоны зан байдлыг засаж, залруулав.

Сургаал буюу зарчим

Шунал тачаал болон ёс суртахуунгүй явдалд бууж өгсөн хүмүүс наманчлахаас нааш Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй.

Биелэлт

Тачаангуй бодол, нүглээ орхихын тулд та юу хийдэг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Алма 41:10

Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.

Агуулга

Алма өөрийн хүү Кориантонд ёс бус явдал болон зөв шударга байдлын мөнхийн үр дагавруудын талаар заав.

Сургаал буюу зарчим

Нүгэл нь мөнхийн аз жаргалыг авчирдаггүй.

Биелэлт

Есүс Христийн сургаал болон үлгэр жишээг дагаснаар таны баяр баясгалан хэрхэн өссөн бэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Хиламан 5:12

Христийн хадан дээр сууриа тавь.

Агуулга

Нифай, Лихай хоёр эцэг Хиламаныхаа зөвлөгөөг дагаж, ёс бус Нифайчуудад номлов.

Сургаал буюу зарчим

Бид амьдралаа зөвхөн Есүс Христэд суурилуулснаар Сатаны уруу таталтуудыг яван гарч чадна.

Биелэлт

Есүс Христийн сайн мэдээ уруу таталтаас хэрхэн хамгаалдаг вэ? Та өөрийн сонголтуудыг Аврагчийн сургаал болон амьдралтай хэрхэн нийцүүлдэг вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

3 Нифай 12:48

Та нар төгс байх ёстой.

Агуулга

Есүс Христ Нифайчуудад дээд хуулиудыг зааж, тэднийг Бурханы хаант улсын гишүүд болоход нь бэлджээ.

Сургаал буюу зарчим

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ төгсийн адил бид ч бас төгс болохыг зарлигуулсан.

Биелэлт

Та Есүс Христтэй адил болохын тулд яг одоо юу хийж чадах вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

3 Нифай 18:15, 20–21

Сэрэмжилж, байнга залбир.

Агуулга

Есүс Нифайчуудад чөтгөрийн уруу таталтыг хэрхэн тэвчихийг заасан.

Сургаал буюу зарчим

Залбирлаар дамжуулан бид уруу таталтыг эсэргүүцэх хүч, зөв шударга хүслийг хүлээн авч, гэр бүл дотроо адислагдах болно.

Биелэлт

Та хувийн болон гэр бүлийн залбирлаа тогтмол үргэлжлүүлэхийн тулд юу хийж чадах вэ?

35 Ай, санагтун, хүү минь, мөн насны залууд ¹мэргэн ухаанд суралц; тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун.

21 Мөн эдүгээ миний итгэлийн талаар хэлсэнчлэн — ¹итгэл бол юмсын тухай төгс мэдлэгтэй байх нь бус юм; тиймийн тул хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд ¹үл харагдах зүйлүүдэд ⁴найдах болно.

11 Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн ²зүдүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

12 Мөн тэрээр ¹үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлсээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно.

13 Эдүгээ Сүнс бүх зүйлийг ¹мэддэг; гэсэн хэдий ч Бурханы Хүү өөрийн хүмүүсийн нүглүүдийг өөр дээрээ авч болохын тулд, тэрээр өөрийн чөлөөлөлтийн хүчний дагуу тэдний зөрчлүүдийг арилгаж болохын тулд бие махбодийн дагуу зовох болно; мөн эдүгээ болгоогтун, надад буй гэрчлэл нь энэ болой.

30 Гэвч өдий зэргийг би та нарт хэлж чадна, хэрэв та нар өөрсдийгөө, мөн ¹бодлуудаа, мөн үгсээ, мөн үйлүүдээ ⁴хянаж, мөн Бурханы зарлигуудыг мөрдөж, бас Их Эзэний маань ирэлтийн талаар сонссон түүндээ үргэлж итгэлтэй байж, бүр амьдралынхаа эцсийг хүртэл ингэхгүй аваас, та нар мөхөх ёстой болно. Мөн эдүгээ, Ай хүмүүн, санагтун, мөн бүү мөхөгтүн.

19 Учир нь ¹эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын уналтаас тийм байсаар ирсэн, мөн тэрээр Ариун ⁴Сүнсний таталтанд ²автагдан, эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар ¹гэгээнтэн болж, ¹хүүхэд шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүр хүүхэд эцэгтээ захирагддаг шиг Их Эзэн түүн дээр ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн бус аваас үүрд мөн үргэлж тийм байх болно.

15 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар чөтгөрөөр уруу татагдаж, мөн та нар түүгээр боолчлогдон удирдагдах болуузай хэмээн та нар үргэлж сэрэмжилж мөн ¹залбирах ёстой.

20 Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гуйх, зөв болох ¹юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөх болно.

21 Эхнэрүүд хийгээд хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд, гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж ¹залбир.

48 Тиймийн тул би, эсвээс тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг ¹төгс байгаасай хэмээнэ би.

12 Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний ¹Гэтэлгэгчийн хадан дээр та нар ¹сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит ⁴шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой.

10 Амилуулалтын талаар яригдсан учир чи нүглээс аз жаргалд сэргээгдэх болно гэж бүү бод. Болгоогтун, би чамд хэлнэ, ¹ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.

9 Эдүгээ хүү минь, би чамайг наманчлаасай мөн нүглүүдээ орхиосой, мөн нүдээрээ ¹шунасныхаа араас дахин бүү яваасай, харин эдгээр бүх зүйлийг өөртөө хориглоосой хэмээнэ; учир нь чи үүнийг хийхгүйгээр Бурханы хаант улсыг өвлөх аргагүй. Ай санагтун, үүнийг өөр дээрээ авч, мөн эдгээр зүйлд өөртөө хориг тавь.



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Ифер 12:6

Итгэлийн сорилтын дарааг хүртэл гэрч ирэхгүй.

Агуулга

Моронай бошиглогч Иферийн үгсийг хураангуйлахдаа өөрийн гэрчлэл, зөвлөмж, итгэлийн тухай цэдэглэв.

Сургаал буюу зарчим

Итгэлтэйгээр тэвчсэний дараа Их Эзэн биднийг сүнслэг баталгаагаар адисладаг.

Биелэлт

Та хэзээ Есүс Христэд итгэх гэрчлэлтэй болсон бэ? Та ямар адислалуудыг хүлээн авсан бэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Ифер 12:27

Сул дорой зүйлүүд хүчирхэг болдог.

Агуулга

Моронай бичихдээ тааруу учир зовниж байв. Их Эзэн түүнд сул дорой байдлаа хэрхэн давж гарахыг зөвлөсөн юм.

Сургаал буюу зарчим

Бурхан биднийг даруусгахын тулд сул дорой болгодог. Хэрэв бид өөрсдөө даруусвал сул дорой байдлууд маань Есүс Христэд итгэх итгэлээр дамжин хүчирхэг болно.

Биелэлт

Хүчирхэг болгохыг Бурханаас гуйх сул дорой байдал тань юу вэ? Та хэрхэн даруу байж, Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Моронай 7:41

Христийн Цагаатгалаар дамжуулан найдварыг тээ.

Агуулга

Мормон аймшигт ёс бус цаг үед итгэл, найдвар, энэрэл нь биднийг Есүс Христтэй адил болоход хэрхэн тусалж чадахыг заасан юм.

Сургаал буюу зарчим

Бид Есүс Христэд итгэдэг учир найдвараа Түүнд болон Түүний Цагаатгал дээр төвлөрүүлэх ёстой.

Биелэлт

Есүс Христийн Цагаатгалд найдах таны найдвар ирээдүйн төлөв байдлыг тань хэрхэн өөрчилсөн бэ? Энэхүү найдвар таны амьдралын хэв маягт хэрхэн нөлөөлж байна вэ?



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Моронай 7:45, 47–48

Энэрэл нь удаан тэсвэрлэдэг.

Агуулга

Мормон аймшигт ёс бус цаг үед итгэл, найдвар, энэрэл нь биднийг Есүс Христтэй адил болоход хэрхэн тусалж чадахыг заасан юм.

Сургаал буюу зарчим

Есүс Христийн үнэн дагалдагч болохын тулд бидэнд энэрэл байх ёстой. Тэрхүү хайраар дүүргэгдэхийн тулд Эцэгт хандан залбирах хэрэгтэй.

Биелэлт

Моронай 7-р бүлэгт гардаг энэрлийн тодорхойлолтыг тунгаан бодож, энэхүү хайрыг гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүст хэрхэн харуулж болохыг Тэнгэрлэг Эцэгээс асуу.



ТӨГС ЭЗЭМШИХ
С У Д А Р

Моронай 10:4–5

Ариун Сүнс үнэнийг илчилдэг.

Агуулга

Моронай бүх зүйл үнэн болохыг, тэр дундаа Мормоны Ном үнэн гэдгийг олж мэдэхийг хүн төрөлхтнөөс хүссэнээр өөрийн бичиглэлээ өндөрлөдөг.

Сургаал буюу зарчим

Чин сэтгэлээсээ, итгэлтэйгээр Бурханаас асуух тэдэнд Ариун Сүнс Мормоны Ном нь үнэн гэдгийг илчлэх болно.

Биелэлт

Мормоны Ном болон “бүх зүйл үнэн гэдгийг” хэрхэн мэдэж болохыг найздаа тайлбарла.

4 Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн^f эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, “чин сэтгэлтэйгээр, ^lүнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний ^lүнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.

5 Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн ^fүнэнийг мэдэж болно.

45 Мөн ^fэнэрэл бол удаан тэсвэрлэдэг, мөн сайхан сэтгэлтэй, мөн атаархаж жөөрхөх нь үгүй, мөн онгирч хөөрдөггүй, өөрийнхийгөө эрэлхийлдэггүй, амар өдөөн хатгагддаггүй, ямар ч хилэнцтийг боддоггүй, мөн алдаст баясах нь үгүй, харин үнэнд баясаг, бүх зүйлийг хүлцдэг, бүх зүйлд итгэдэг, бүх зүйлд найддаг, бүх зүйлийг тэвчдэг.

47 Гэвч ^fэнэрэл бол Христийн цэвэр хайр, мөн энэ нь үүрд үл цохрох ажгуу; мөн эцсийн өдөр үүнийг эзэмшиж байгаа хэнд боловч, түүнд сайн байх болно.

48 Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний лутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; та нар Бурханы хөвгүүд болж болохын тулд; тэрбээр хүрч ирэхэд бид түүнтэй адил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно гэсний учир, бидэнд энэ найдвар байж болохын тулд, түүний цэврийн адил бид тэвэр болгогдож болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Энэгт хандан залбиратгун. Амен.

41 Мөн та нар юуны төлөө ^fнайдах билээ? Болгоогтун та нар Христийн цагаатгал, мөн түүний амилалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд ^dнайдахыг би та нарт хэлье, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой.

27 Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь ^fсул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд “сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож ^lөгнө.

6 Мөн эдүгээ, би, Моронай, эдгээр зүйлийн талаар заримыг ярья; ^fитгэл бол найддагдсан боловч ^dүзэгдээгүй зүйлүүд гэдгийг би дэлхийд үзүүлнэ; иймийн тул, та нар хараагүйн улмаас бүү арсалд, учир нь итгэлийн тань “сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг хүлээн авахгүй.

Мормоны Номыг унших хүснэгт

1 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
2 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30	31	32	33
Иаков	1	2	3	4	5	6	7				
Инос	1										
Жером	1										
Омнаи	1										
Мормоны үгс		1									
Мозая	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29				
Алма	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30	31	32	33
	34	35	36	37	38	39	40	41	42	43	44
	45	46	47	48	49	50	51	52	53	54	55
	56	57	58	59	60	61	62	63			
Хиламан	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16						
3 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30			
4 Нифай	1										
Мормон	1	2	3	4	5	6	7	8	9		
Ифер	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15							
Моронай	1	2	3	4	5	6	7	8	9	10	

Мормоны Номыг унших хүснэгт

1 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
2 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30	31	32	33
Иаков	1	2	3	4	5	6	7				
Инос	1										
Жером	1										
Омнаи	1										
Мормоны үгс		1									
Мозая	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29				
Алма	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30	31	32	33
	34	35	36	37	38	39	40	41	42	43	44
	45	46	47	48	49	50	51	52	53	54	55
	56	57	58	59	60	61	62	63			
Хиламан	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16						
3 Нифай	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
	23	24	25	26	27	28	29	30			
4 Нифай	1										
Мормон	1	2	3	4	5	6	7	8	9		
Ифер	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	12	13	14	15							
Моронай	1	2	3	4	5	6	7	8	9	10	

